



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 05 сарын 02 өдөр

Дугаар 158

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн  
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнийг чөлөөлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4.7.4 дэх заалт Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2023 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн ХЭГ/989 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын референт Г.Эрдэнэбулган нь эрхэлсэн ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн тул “Монголын цахилгаан холбоо” хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэх гишүүнээс 2023 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ